



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/691

Улаанбаатар хот

### Баянгол дүүргийн Цагдаагийн газрын эд хөрөнгийг данснаас дансанд шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 27,653,732.00 (хорин долоон сая зургаан зуун тавин гурван мянга долоон зуун гучин хоёр) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг үндсэн хөрөнгийн холбогдох дансанд, эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй 1,920,000.00 (нэг сая есөн зуун хорин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг үндсэн хөрөнгийн холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Баянгол дүүргийн Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг)-т зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В. Оюунмаа* ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны ᠘ дугаар сарын ᠔ -ны өдрийн ᠕69/ дугаар тушаалын хавсралт

Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн цагдаагийн газар

| Д/Д                                                | Хөрөнгийн нэр                 | Марк дугаар   | Ашиглалтад орсон огноо | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Бүртгэх анхны |              | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Дансны нэр                             |                              |
|----------------------------------------------------|-------------------------------|---------------|------------------------|--------------|-------------|------------|---------------|--------------|-----------------------|--------------|----------------------------------------|------------------------------|
|                                                    |                               |               |                        |              |             |            | Нэгж үнэ      | Нийт үнэ     |                       |              | Шилжүүлэх данс                         | Бүртгэх данс                 |
| Бараа материалаас үндсэн хөрөнгийн дансанд         |                               |               |                        |              |             |            |               |              |                       |              |                                        |                              |
| 1                                                  | Согтолт хэмжигч багаж         | 1100          | 2019.01.01             | хэвийн       | ш           | 1          | 320,000.0     | 320,000.0    | -                     | 320,000.00   | Тусгай зориулалттай материал           | Машин тоног төхөөрөмж        |
| 2                                                  | Согтуурал хэмжигч             | 1100          | 2019.01.01             | хэвийн       | ш           | 5          | 320,000.0     | 1,600,000.0  | -                     | 1,600,000.0  | Тусгай зориулалттай материал           | Машин тоног төхөөрөмж        |
| Тусгай зориулалттай материал                       |                               |               |                        |              |             |            |               | 1,920,000.0  | -                     | 1,920,000.0  |                                        |                              |
| Үндсэн хөрөнгийн данснаас бараа материалын дансанд |                               |               |                        |              |             |            |               |              |                       |              |                                        |                              |
| 3                                                  | Хийн буу                      | Relay X Treme | 2015.07.22             | хэвийн       | ш           | 8          | 107,904.0     | 863,232.0    |                       | 863,232.0    | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай | Тусгай зориулалттай материал |
| Батлан хамгаалах, цэргийн зориулалттай             |                               |               |                        |              |             |            |               | 863,232.0    | -                     | 863,232.0    |                                        |                              |
| Үндсэн хөрөнгийн данс хооронд                      |                               |               |                        |              |             |            |               |              |                       |              |                                        |                              |
| 4                                                  | Төмөр шон                     |               | 2021.08.25             | хэвийн       | ш           | 28         | 825,000.0     | 23,100,000.0 | 2,310,000.0           | 20,790,000.0 | Машин тоног төхөөрөмж                  | Барилга байгууламж           |
| 5                                                  | Барилга байгууламж дээрхи шон |               | 2023.12.30             | хэвийн       | ш           | 9          | 335,500.0     | 3,019,500.0  | 754,875.2             | 2,264,624.8  | Машин тоног төхөөрөмж                  | Барилга байгууламж           |
| 6                                                  | Барилга байгууламж дээрхи шон |               | 2023.12.30             | хэвийн       | ш           | 2          | 335,500.0     | 671,000.0    | 335,500.0             | 335,500.0    | Машин тоног төхөөрөмж                  | Барилга байгууламж           |
| Машин тоног төхөөрөмж                              |                               |               |                        |              |             |            |               | 26,790,500.0 | 3,400,375.1           | 23,390,124.8 |                                        |                              |
| Нийт данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн дүн      |                               |               |                        |              |             |            | 53.0          | 29,573,732.0 | 3,400,375.1           | 26,173,356.8 |                                        |                              |